



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.05.02-2022.05.06



ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022.05.09-ний after trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
DOW	32,508.00	-1.46%	-1.43%	-6.01%	-6.53%
S&P 500	4,073.04	-1.77%	-1.45%	-9.51%	-3.79%
NASDAQ	12,560.00	-2.28%	-2.36%	-13.63%	-8.52%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
GB100	7,388.00	-1.54%	-2.08%	-2.17%	3.62%
DE40	13,674.00	-1.64%	-3.00%	-2.87%	-11.20%
FR40	6,258.00	-1.73%	-4.22%	-3.15%	-1.99%
IT40	23,476.00	-1.20%	-3.20%	-3.40%	-4.62%
ES35	8,33.00	-1.34%	-3.05%	-1.72%	-8.14%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
JP225	26,432.00	-1.53%	-1.66%	-1.92%	-10.17%
SHANGHAI	3,005.00	-2.06%	-1.24%	-7.02%	-11.98%
CSI 300	3,891.00	-2.97%	-2.90%	-7.35%	-21.94%
CH50	13,032.17	-0.54%	-3.20%	-3.95%	-22.61%
SENSEX	54,836.00	-1.56%	-3.90%	-7.11%	11.44%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Газрын тос (Crude Oil)	110.07	1.69%	5.15%	15.25%	69.61%
Газрын тос (Brent)	112.88	1.83%	5.29%	12.75%	65.22%
Байгалийн хий	8.0900	-7.89%	11.66%	25.68%	173.46%
Шатахуун	3.7950	3.73%	10.15%	25.53%	78.27%
Нүүрс	379.50	1.38%	16.30%	33.16%	294.70%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
Алт	1,875.90	-0.04%	-1.06%	-2.89%	2.50%
Мөнгө	22.255	-1.10%	-2.11%	-9.40%	-18.85%
Зэс	4.2240	-1.41%	-3.89%	-10.12%	-11.37%
Бонд	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	Он гарснаас хойш
АНУ	3.1424	0.1078	0.21%	0.48%	1.57%
Англи	2.0080	0.0440	0.10%	0.28%	1.23%
Швейцар	1.0180	0.1030	0.18%	0.31%	1.28%
Испани	2.2460	0.0990	0.27%	0.58%	1.75%
Португаль	2.2880	0.1020	0.26%	0.69%	1.78%

Эх сурвалж: Trading economics

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

5 сар гарснаар бид юуг мэдэж байв?

- Инфляц ойрын 40 жилд байгаагүй дээд хэмжээнд хүрсэн
- Төв банкнаас энэхүү инфляцын өсөлтийг хяналтад оруулахаар хатуу мөнгөний бодлого баримталж эхэлсэн
- Эдийн засгийн хувьд харьцангуй сайн байгаа. Ялангуяа ажил эрхлэлт болон өрхийн худалдан авалт түүхэн дээд түвшинд байгаа нь хямрал болохоос сэргийлж магадгүй байна.
- АНУ-ын компаниудын орлого боломжийн хэмжээнд байгаа ба энэ жилдээ өсөх хандлагатай.
- Хөрөнгийн зах зээл ХНСанг хэт хатуу бодлого баримтлан эдийн засгийн хямралд оруулах вий гэснээс болж ихээхэн унаад байна
- Бондын өгөөж бодлогын хүү өсөж байгаатай зэрэгцэн хүчтэй өсөж байна.



Өнгөрсөн 7 хоногт болсон үйл явдлаас бид юуг олж мэдэв?

- Инфляц хүчтэй өсөж байгаа ч оргил цэгтээ хүрсэн байж болзошгүй ба бага зэргээр буурч байгаа ажиглагдаж байна.
- ХНС-аас бодлогын хүүгийн эхний ээлжийн 0.5%-ийн нэмэлтүүд явж өнгөрсөн ба одоохондоо 0.75%-иар өсгөхгүй байх бодолтой байгаагаа мэдэгдсэн.
- Хөрөнгийн зах зээлд ихээхэн хэмжээний "correction" уналтын хөдөлгөөнүүд явж байгаа ба технологийн компаниудын үнэлгээ бодлогын хүү өсөж байгаатай холбоотой буурч байна.

Эх сурвалж: www.edwardjones.com

Шинжээчид дараах 3 зүйлсэд анхаарал хандуулж байна

1. ХНС инфляцыг бууруулахаар мөнгөний бодлогыг хэрхэн удирдаж явуулах вэ?

ХНС өнгөрсөн 7 хоногт бодлогын хүүг дахин 0.5%-иар өсгөсөн нь ойрын 22 жилд өсгөж байгаагүй их хувь юм. Энэхүү мэдээллээс шинжээчид ХНСанг инфляцын түвшинг бууруулахаар хүчтэй тэмцэх гэж байгаа гэж ойлгосон ба дараагийн 2 хорооны хурлаар дахин 0.5%-иар нэмж өсгөнө гэж хүлээж байна. ХНС бодлогын хүүг хэдий хүчтэй өсгөж байгаа ч эдийн засгийн өсөлтийг золиосонд гаргахгүй болов уу.

ХНС 1980 онд инфляцыг хяналтад авахаар зориуд эдийн засгийн хямрал эхлүүлсэн ба бодлогын хүүг 10%-иас 22% хүртэл өсгөж байсан. Харин 1994 онд бодлогын хүүг 3%-иас 6% болгон өсгөсөн боловч эдийн засаг хямраагүй юм. Энэ жил шинжээчид бодлогын хүүг нийт 2.5%-иар өснө гэж төсөөлж байна.

АНУ-ын инфляцын түвшин /хувиар/



2. Хөрөнгийн зах зээл эдийн засгийн хямралыг хүлээж байна

Өнгөрсөн жилийн халамжийн тэтгэмж, хэрэглээний үнийн өсөлт, нийлүүлэлтийн удаашрал зэргээс үүдэлтэй эдийн засгийн өсөлт саарсан. Нэмээд энэ жилээс эхлээд ХНС хатуу мөнгөний бодлого баримтлах байр суурьтай байгаа зэргийг харгалзан шинжээчдийн зүгээс эдийн засгийн хямрал болохыг хүлээж байж магадгүй харагдаж байгаа боловч эдийн засаг хангалттай сайн байгааг илтгэх хэд хэдэн үзүүлэлтүүд байна. Жишээлбэл 4 сард 428 мянган шинэ ажлын байр нэмэгдсэнээр ажилгүйдлийн түвшин 3.6%-д хүрсэн нь 50 жилд үзэгдэж байгаагүй доод хэмжээ юм.

Эх сурвалж: www.edwardjones.com

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

3. Хөрөнгийн зах зээл хэдий уналтад орсон ч бүр мөсөн гарах харахан болоогүй байна

Өнгөрсөн 7 хоногт хөрөнгийн зах зээлд болсон хэлбэлзэл их өндөртэй байлаа. Dow Jones индекс Лхагва гарагт 900 нэгж өссөнөө дараагийн өдөр нь 1000 нэгжээр унасан бол Nasdaq индекс 2020 оны 6 сараас хойш хамгийн хүчтэй уналтыг үзүүлсэн юм.

Хөрөнгийн зах зээл 1-р сарын оргил цэгээс ойролцоогоор 14%-иар унаад байгаа нь correction хөдөлгөөний хувьд дундаж уналт юм. Энэхүү correction хөдөлгөөний гол шалтгаан нь хувьцаануудын үнэлгээ буурсантай их холбоотой. Ирээдүйг харсан P/E үнэлгээ 2022 он гарснаар 21% унаад байна. Өнгөрсөн удаагийн ХНС-ийн хатуу мөнгөний бодлоготой холбоотойгоор дундаж P/E харьцаа 20%-иар унаж байсан. Үүнээс харахад энэ удаагийн хөрөнгийн зах зээлийн уналт ханасан байж магадгүй харагдаж байна.



Эх сурвалж: www.edwardjones.com